

ЭЛСЭЛТИЙН ЗААВАРЧИЛГАА

ЭЛСЭЛТИЙН

хугацаа

4-р сар /7-р сар /10-р сар /1-р сар



Элсэлтийн бодлого, чиглэл

Дэлхийн тавцанд мэдлэг, ур чадвараараа амжилт гарган, тэргүүлэх чин хүсэлтэй, Япон улсын Их дээд сургуулиудад дэвшин суралцаж мэргэжил боловсрол эзэмших зорилготой, Их дээд сургуульд элсэн суралцахад шаардлагатай суурь мэдлэгтэй, суралцах арга барил эзэмшсэн, сэтгэн бодох чадвартай, аливааг сонирхон судлах хүсэл эрмэлзэл бүхий хэн бүхэнд Охара эрдэмийн хүрээлэнгийн харъяа Охара Япон хэлний сургуулийн үүд хаалга үргэлж нээлттэй байна.

**“Бид сургуульдаа доорхи зан төлөв,
хүсэл эрмэлзэл бүхий оюутан залуусыг урьж байна.”**

- Япон улсын хууль тогтоомж, сургуулийн дүрэм журмыг дагаж мөрдөх чадвартай.
- Их дээд сургууль, мэргэжлийн сургуульд суралцахад шаардлагатай өндөр түвшний япон хэл сурах, Японы тухай мэдлэгтэй болох хүсэлтэй.
- Нийгмийн нэгэн эд эс, иргэн хүнийхээ хувьд үүрэг хариуцлагаа ухамсарласан.Бие даасан. Бусдын соёл, ялгаатай байдлыг хүндлэх , аливаад уян хатан, ухаалагаар хандах сэтгэлтэй.
- Япон болон олон улсад ажил мэргэжлээрээ тэргүүлэн амжилт гаргах хүсэл эрмэлзэлтэй.
- Япон хэл болон Японы зан заншлыг судлан суралцаж, ирээдүйд Япон болон дэлхийн бусад улс орон хоорондын гүүр болох чин хүсэлтэй.

Агуулга гарчиг

1. Элсэн суралцах хүртэлх явц, дараалал	1
2. Элсэгчид тавих нөхцөл	2
3. Суралцах курс , элсэх хугацаа, бичиг баримт хүлээн авах эцсийн хугацаа	2
4. Суралцах хүсэлт гаргах, хэрхэн бүртгүүлэх тухай.....	2
5. Хичээлийн цагийн хуваарь.....	2
6. Бүртгэлийн хураамж	4
7. Сургалтын төлбөр	4
8. Бүртгэлийн хураамж болон сургалтын төлбөр төлөх дансны мэдээлэл	6
9. Элсэлтээс татгалзах (цуцлах) үед төлбөрийн буцаан олгох тухай журам	7
10. Бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт	7
11. Хувийн мэдээлэлийн нууцлалын тухай.....	9

1. Элсэн суралцах хүртэлх явц, дараалал

1.Бичиг баримт бүрдүүлэлт Дэлгэрэнгүйг (8-9 хуудаснаас лавлах)	1.Бүртгүүлэгч нь заасан хугацааны дотор элсэлтийн бичиг баримт материалаа бүрдүүлэн сургууль руу илгээнэ. 2.Хүлээн авсан баримт материалыг эцсийн байдлаар шалган, суралцах зөвшөөрөл олгох эсэхийн шийднэ. 3.Бичиг баримт нь бүрэн бүтэн, асуудалгүй бол “элсэн суралцах зөвшөөрөл” - ийн бичгийг гардуулна.
↓	
2.Оршин суух зөвшөөрөл	Сургуулийн захиргаанаас бүх элсэгчдийнхээ “Оршин суух зөвшөөрөл” хүсэх өргөдлийг Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газарт хүлээлгэн өгнө.
↓	
3.Оршин суух зөвшөөрөлийн хариу	Оршин суух зөвшөөрөл хүссэн өргөдлийн хариуг төлөөлөгчийн газраар дамжуулан (хувиараа хандсан бол шууд) мэдэгдэнэ. Амжилттай хариу гарсан бол “Оршин суух зөвшөөрөлийн гэрчилгээ”-ний хуулбарыг илгээнэ. Та ОСЗ-н гэрчилгээн дэх таны хувийн мэдээлэл паспортны мэдээлэлтэй зөрүүгүй эсэхийг нягтлан шалгаарай. Хэрвээ ямар нэг алдаа байгааг анзаарвал яаралтай сургуульд мэдэгдээрэй.
↓	
4.Сургалтын төлбөр (5-6 хуудаснаас лавлах)	Заасан хугацааны дотор сургалтын төлбөрөө шилжүүлэх
↓	
5.Түвшин тогтоох шалгалт өгөх	Элсэлтийн зааварчилгаанд заасан хугацаанд сургуулийн Япон хэлний түвшин тогтоох шалгалт өгөх. Шалгалтын дүнгээр, тохирсон ангид нь хуваарилна.
↓	
6.Бичиг баримт буцаан олгох тухай	Сургалтын төлбөр шилжүүлсний дараа, бид доорхи бичиг баримтыг шуудангаар илгээнэ. (Элсэн суралцагчид эсвэл төлөөлөгчийн газар руу илгээнэ.) • Оршин суух зөвшөөрөлийн гэрчилгээ • Элсэн суралцах зөвшөөрөлийн бичиг • Элсэлтийн зааварчилгаа • Төгсөлтийн гэрчилгээний эх хувь (бичиг баримт бүрдүүлэлтийн үеэр авсан)
↓	
7.Гадаад дахь консулын газарт виз мэдүүлэх	Япон улсын элчин сайдын яам, консулын газар виз мэдүүлнэ үү. <i>※Виз мэдүүлэхэд шаардлагатай бичиг баримтуудыг тухайн газар нутгийн консулын газраас лавлах.</i>
↓	
8.Байр болон нислэгийн тийзийн захиалг	1.Орон сууц амьдрахыг хүсэж байгаа байрны мэдээлэлээ бидэнд эсвэл төлөөлөгчийн газарт мэдэгдээрэй. <i>※Байр орон сууцаа өөрөө олоод гэрээ хийж болно.</i> 2.Элсэлтийн зааварчилгаанд заасан хугацаанд амжин Японд ирэхээр онгоцны тизээ авах. Ирэх өдөр нь тодорхой болмогц сургуульдаа эсвэл төлөөлөгчийн газарт мэдэгдэх.
↓	
9.Японд ирэх	1. Япон улсад нэвтрэх үедээ хилийн шалганы цонхон дээрээс дараах зүйлсийг авах хүсэлтээ гаргах: а) Оршин суугчийн карт б) Үйл ажиллагааны зөвшөөрөл буюу цагын ажил хийх зөвшөөрөл 2. Япон улсад ирээд 14 хоногийн дотор өөрийн оршин суугаа газрын харъяа дүүргийн захиргаанд “оршин суугчийн бүртгэл”-ээ хийлгэх болон “эрүүл мэндийн даатгал”-д орох шаардлагатай. 3. Элсэлтийн ёслолийн үйл ажиллагаандаа оролцон, хичээлдээ сууж эхэлнэ.

2. Элсэгчид тавих нөхцөл

[Гадаадад амьдарч буй бол]

- ① Улс эх орондоо ахлах сургууль төгсөн, адистатаа авсан байх. Японы их дээд сургуульд элсэн суралцах бол албан ёсны боловсролын системийн дагуу 12 жилээр сургуулиа төгссөн байх шаардлагатай.

*Японд дэвшин суралцахаар төлөвлөөгүй бол энэ заалт хамаарахгүй.

- ② Япон хэлний түвшин тогтоох шалгалтын N5 болон түүнээс дээш түвшний батламжтай байх. Эсвэл үүнтэй дүйцэхүйц чадвартай гэдгээ бодитоор нотлох.

*Элсэлтийн хугацаанаас хамааран хэлний түвшинд тавигдах шаардлага ялгаатай байна.

- ③ Зардалын батлан даагч нь сургалтын төлбөр болон амьжиргааны зардлыг гаргах бөгөөд зардалыг бүрэн даах санхүүгийн чадамжаа нотлох хэрэгтэй.

※Гадаадын иргэн 6 сараас дээш хугацаагаар Японд боловсрол эзэмшихэд оюутны виз авах шаардлагатай байдаг ба "Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ"-г авсанаар оюутаны виз мэдүүлэх эрхтэй болно. Япон хэлний сургалтын байгууллага нь оюутануудаа (элсэн суралцах хүсэлт гаргагч) төлөөлөн "Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ" авах өргөдөлийг Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газарт өргөн барьдаг. Өргөдөл гаргахад дээрхи нөхцөлийг бүрэн хангасан байх хэрэгтэй.

[Япон улсад амьдарч буй бол]

Элсэлтийн үеэс эхлэн тасралтгүй 1 жилээс дээш хугацаагаар Японд оршин суух боломжтой визтэй байх ба дээр дурдсан①~③ шаардлагыг хангасан байх.

3. Суралцах курс , элсэх хугацаа, бичиг баримт хүлээн авах эцсийн хугацаа

№	Элсэн суралцаж эхлэх хугацаа	Курс хөтөлбөр	Хэлний түвшин (элсэх үед)	Бичиг баримт хүлээн эцсийн хугацаа
1	4-р сар	Дэвшин суралцах -2 жилийн	N5~	Элсэх жилийн өмнөх 10-р сарын сүүлээр
2	4-р сар	Дэвшин суралцах -1 жилийн	N3~	Элсэх жилийн өмнөх 10-р сарын сүүлээр
3	7-р сар	Дэвшин суралцах -1 жил 9 сар	N5~N4	2-р сарын сүүлээр
4	10-р сар	Дэвшин суралцах -1 жил 6 сар	N4~	5-р сарын дундуур
5	1-р сар	Дэвшин суралцах -1 жил 3 сар	N3~	Элсэх жилийн өмнөх 8-р сарын сүүлээр

※Бүртгэлийн тоо хязгаартай. Оюутны тоо гүйцсэн тохиолдолд, хугацаанаас өмнө бүртгэлийг зогсооно. Шаардлагатай бичиг баримтуудыг аль болох хурдан илгээнэ үү.

4. Суралцах хүсэлт гаргах, хэрхэн бүртгүүлэх тухай

- ① Суралцах хүсэлтэй та бүхэн манай төлөөлөгчийн газруудад хандана уу.
② Зардалын батлан даагч нь Япон улсад оршин суудаг бол, манай сургууль руу шууд холбогдон суралцах хүсэлтээ гаргах боломжтой.

Сургуулийн хаяг:

Магадлан итгэмжлэгдсэн боловсролын байгууллага
Охара эрдэмийн хүрээлэнгийн харъяа Охара Япон хэлний сургууль
Ерөнхий алба болон Марктенгийн албаны хэлтэс
Токио хот, Эдогава дүүрэг, Фунабори 1-4-14, Утас: +81-3-3237-7120
И-мэйл: info.ojls@mail.o-hara.ac.jp

5. Хичээлийн цагийн хуваарь

- Өглөөний анги 9:00 ~ 12:10
- Үдээс хойшхи анги 13:00 ~ 16:10

※Хичээлийн цагийг анги хуваарилалт болон шалгалтын дүнгээр шийднэ. Оюутнууд хичээлийн цагийг сонгох боломжгүй.

Сургалтын хөтөлбөрийн жишээ

Өглөөний анги 9:00 ~ 12:10	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
9:00 1-р цаг 9:45	Үндсэн сурах бичиг /үгсийн сан/	Үндсэн сурах бичиг/өгүүлбэрийн бүтэц/	Үндсэн сурах бичиг/сонсох/	Үндсэн сурах бичиг/унших/	Үндсэн сурах бичиг/шалгалт/
9:45 2-р цаг 10:30	Үндсэн сурах бичиг/өгүүлбэрийн бүтэц/	Үндсэн сурах бичиг/яриа/	Үндсэн сурах бичиг/дасгал/	Үндсэн сурах бичиг/унших/	Үндсэн сурах бичиг/илтгэх дасгал/
10:30 ~ 10:40	Завсарлага				
10:40 3-р цаг 11:25	Багийн ажил	Харилцан яриа	Багийн ажил	Сонсох	Дэвшин уралцах төлөвлөгөө Эссэ бичих
11:25 4-р цаг 12:10	Ханз, Үгсийн сан	Ханз, Үгсийн сан	Ханз, Үгсийн сан	Ханз, Үгсийн сан	Ханз, Үгсийн сан

Өдрийн анги 13:00 ~ 16:10	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
13:00 1-р цаг 13:45	Үндсэн сурах бичиг /үгсийн сан/	Үндсэн сурах бичиг/өгүүлбэрийн бүтэц/	Үндсэн сурах бичиг/унших хэлэлцэх/	Үндсэн сурах бичиг /илтгэл/	Үндсэн сурах бичиг /шалгалт/
13:45 2-р цаг 14:30	Үндсэн сурах бичиг/өгүүлбэрийн бүтэц/	Үндсэн сурах бичиг /сонсох/	Үндсэн сурах бичиг/харилцан яриа, дуудлага/	Үндсэн сурах бичиг /илтгэл/	Ангийн багшийн зөвлөгөө Дэвшин суралцах төлөвлөлийн зөвлөгөө
14:30 ~ 14:40	Завсарлага				
14:40 3-р цаг 15:25	ЈLPT бэлтгэх хичээл	ЕЈU бэлтгэх хичээл	ЈLPT бэлтгэх хичээл	ЕЈU бэлтгэх хичээл	ЈLPT бэлтгэх хичээл
15:25 4-р цаг 16:10	Ханз, Үгсийн сан	Цаг үеийн байдал, мэдээ	Ханз, Үгсийн сан	Цаг үеийн байдал, мэдээ	Ханз, Үгсийн сан

Японы Их дээд сургуульд суралцах шалгалт (ЕЈU)-ын суурь хичээлийн шалгалтанд бэлтгэх сонгон суралцах хичээлүүд орно.

※ Суралцах хүсэлтэй хүмүүс сонгон суралцах боломжтой.

	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
9:00 1-р цаг 10:30 2-р цаг		TOEIC/TOEFL	Ерөнхий хичээл Хими	TOEIC/TOEFL	Хими
10:30~10:40	Завсарлага				
10:40 3-р цаг 12:10 4-р цаг		Ерөнхий хичээл Математик 2	Математик 1 Физик	Ерөнхий хичээл Математик 2	Математик 1 Физик

Үндсэн хичээлүүд

Хичээллэх хугацаа : 4 дүгээр сарын дунд үеэс 9 дүгээр сарын дунд үе хүртэл

Хүмүүнлэгийн ШУ-ны чиглэл : Ерөнхий хичээл, Математик1, TOEFL/TOEIC

Байгалийн ШУ-ны чиглэл : Математик 2, Физик, Хими, TOEFL/TOEIC

- ЕЈU буюу Японы Их дээд сургуульд суралцах шалгалтанд бэлдэх хичээлүүдийг Охара эрдэмийн хүрээлэнгийн багш нар удирдан явуулна.
- Тус хичээлийн цагын хуваарьт урьдчлан мэдэгдэлгүйгээр гэнэтийн өөрчлөлт орох тохиолдол бий.
- ЕЈU буюу Японы Их дээд сургуульд суралцах шалгалтанд бэлдэх хичээл нь төлбөртэй.

6. Бүртгэлийн хураамж

Сургуульд элсэн орох бүртгэл болон бичиг баримт бүрдүүлэлтийн хураамжийг нэхэмжилнэ.

- Бүртгэлийн хураамж: JPY 30,000

※Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газраас "Оршин суух зөвшөөрөлийн гэрчилгээ"-г олгохгүй гэсэн хариу гарсан тохиолдолд ч бүртгэлийн хураамжийг буцаан олгогдохгүй болно.

※Мөн, оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ олгогдож, виз мэдүүлэхэд гадаад дахь дипломат төлөөлөгчийн газар (Японы элчин сайдын яам, консулын газар гэх мэт) нь виз олгохоос татгалзсан тохиолдолд ч мөн адил элсэлтийн хураамжийг буцаан олгохгүй.

7. Сургалтын төлбөр

1. Дэвшин суралцах - 1 жилийн курс 【Элсэлт 4-р сар】

Мөнгөн тэмдэгт:JPY

Төлөх хугацаа		Нийт	Бүртгэлийн хураамж	Элсэлтийн төлбөр	Сургалтын төлбөр	Сурах бичиг	Ашиглалтын төлбөр
Эхний жил	Оршин суух зөвшөөрөл гарахад	800,000	30,000	80,000	580,000	30,000	80,000
Нийт төлбөр		800,000	30,000	80,000	580,000	30,000	80,000

2. Дэвшин суралцах - 2 жилийн курс 【Элсэлт 4-р сар】

Мөнгөн тэмдэгт:JPY

Төлөх хугацаа		Нийт	Бүртгэлийн хураамж	Элсэлтийн төлбөр	Сургалтын төлбөр	Сурах бичиг	Ашиглалтын төлбөр
Эхний жил	Оршин суух зөвшөөрөл гарахад	800,000	30,000	80,000	580,000	30,000	80,000
2 дох жил		690,000	-	-	580,000	30,000	80,000
Нийт төлбөр		1,490,000	30,000	80,000	1,160,000	60,000	160,000

3. Дэвшин суралцах - 1 жил 9 сарын курс 【Элсэлт 7-р сар】

Мөнгөн тэмдэгт:JPY

Төлөх хугацаа		Нийт	Бүртгэлийн хураамж	Элсэлтийн төлбөр	Сургалтын төлбөр	Сурах бичиг	Ашиглалтын төлбөр
Эхний жил	Оршин суух зөвшөөрөл гарахад	800,000	30,000	80,000	580,000	30,000	80,000
2 дох жил		517,500	-	-	435,000	22,500	60,000
Нийт төлбөр		1,317,500	30,000	80,000	1,015,000	52,500	140,000

4. Дэвшин суралцах - 1 жил 6 сарын курс 【Элсэлт 10-р сар】

Мөнгөн тэмдэгт:JPY

Төлөх хугацаа		Нийт	Бүртгэлийн хураамж	Элсэлтийн төлбөр	Сургалтын төлбөр	Сурах бичиг	Ашиглалтын төлбөр
Эхний жил	Оршин суух зөвшөөрөл гарахад	800,000	30,000	80,000	580,000	30,000	80,000
2 дох жил		345,000	-	-	290,000	15,000	40,000
Нийт төлбөр		1,145,000	30,000	80,000	870,000	45,000	120,000

5. Дэвшин суралцах - 1 жил 3 сарын курс 【Элсэлт 1-р сар】

Мөнгөн тэмдэгт:JPY

Төлөх хугацаа		Нийт	Бүртгэлийн хураамж	Элсэлтийн төлбөр	Сургалтын төлбөр	Сурах бичиг	Ашиглалтын төлбөр
Эхний жил	Оршин суух зөвшөөрөл гарахад	800,000	30,000	80,000	580,000	30,000	80,000
2 дох жил		172,500	-	-	145,000	7,500	20,000
Нийт төлбөр		972,500	30,000	80,000	725,000	37,500	100,000

Сургалтын төлбөр хувааж төлөх тухай

Төлбөрөө хувааж төлөх хүсэлтэй бол сургуультайгаа урьдчилан зөвлөх шаардлагатай. Хэрвээ төлбөрөө хувааж төлвөл, төлбөрийн дараагийн төлөлт хийх хугацааг сургуулиас мэдэгдэнэ.

1. Дэвшин суралцах - 1 жилийн курс [Элсэлт 4-р сар]

Мөнгөн тэмдэгт: JPY

Төлөх хугацаа		Нийт	Бүртгэлийн н хураамж	Элсэлтийн төлбөр	Сургалтын төлбөр	Сурах бичиг	Ашиглалт ын төлбөр
Эхний төлөлт	Оршин суух зөвшөөрөл гарахад	455,000	30,000	80,000	290,000	15,000	40,000
Сүүлийн төлөлт	Элссэн оны 8 сарын 31	345,000	-	-	290,000	15,000	40,000
Нийт төлбөр		800,000	30,000	80,000	580,000	30,000	80,000

2. Дэвшин суралцах - 2 жилийн курс [Элсэлт 4-р сар]

Мөнгөн тэмдэгт: JPY

Төлөх хугацаа		Нийт	Бүртгэлийн н хураамж	Элсэлтийн төлбөр	Сургалтын төлбөр	Сурах бичиг	Ашиглалт ын төлбөр
Эхний төлөлт	Оршин суух зөвшөөрөл гарахад	455,000	30,000	80,000	290,000	15,000	40,000
2-р төлөлт	Тухайн жилийн 8 сарын 31	345,000	-	-	290,000	15,000	40,000
3-р төлөлт	Дараа жилийн 2 сарын 28	345,000	-	-	290,000	15,000	40,000
Сүүлийн төлөлт	Дараа жилийн 8 сарын 31	345,000	-	-	290,000	15,000	40,000
Нийт төлбөр		1,490,000	30,000	80,000	1,160,000	60,000	160,000

3. Дэвшин суралцах - 1 жил 9 сарын курс [Элсэлт 7-р сар]

Мөнгөн тэмдэгт: JPY

Төлөх хугацаа		Нийт	Бүртгэлийн н хураамж	Элсэлтийн төлбөр	Сургалтын төлбөр	Сурах бичиг	Ашиглалт ын төлбөр
Эхний төлөлт	Оршин суух зөвшөөрөл гарахад	455,000	30,000	80,000	290,000	15,000	40,000
2-р төлөлт	Тухайн жилийн 11 сарын 30	345,000	-	-	290,000	15,000	40,000
3-р төлөлт	Дараа жилийн 5 сарын 31	345,000	-	-	290,000	15,000	40,000
Сүүлийн төлөлт	Дараа жилийн 11 сарын 30	172,500	-	-	145,000	7,500	20,000
Нийт төлбөр		1,317,500	30,000	80,000	1,015,000	52,500	140,000

4. Дэвшин суралцах - 1 жил 6 сарын курс [Элсэлт 10-р сар]

Мөнгөн тэмдэгт: JPY

Төлөх хугацаа		Нийт	Бүртгэлийн н хураамж	Элсэлтийн төлбөр	Сургалтын төлбөр	Сурах бичиг	Ашиглалт ын төлбөр
Эхний жил	Оршин суух зөвшөөрөл гарахад	455,000	30,000	80,000	290,000	15,000	40,000
2-р төлөлт	Дараа жилийн 2 сарын 28	345,000	-	-	290,000	15,000	40,000
Сүүлийн төлөлт	Дараа жилийн 8 сарын 31	345,000	-	-	290,000	15,000	40,000
Нийт төлбөр		1,145,000	30,000	80,000	870,000	45,000	120,000

5. Дэвшин суралцах - 1 жил 3 сарын курс [Элсэлт 1-р сар]

Мөнгөн тэмдэгт: JPY

Төлөх хугацаа		Нийт	Бүртгэлийн хураамж	Элсэлтийн төлбөр	Сургалтын төлбөр	Сурах бичиг	Ашиглалтын төлбөр
Эхний жил	Оршин суух зөвшөөрөл гарахад	455,000	30,000	80,000	290,000	15,000	40,000
2-р төлөлт	Тухайн жилийн 5 сарын 31	345,000	-	-	290,000	15,000	40,000
Сүүлийн төлөлт	Тухайн жилийн 11 сарын 30	172,500	-	-	145,000	7,500	20,000
Нийт төлбөр		972,500	30,000	80,000	725,000	37,500	100,000

EJU буюу Японы Их дээд сургуульд суралцах шалгалтанд бэлдэх хичээлүүдийн тухай

※Өөрийн хүсэлтээр сонгон суралцах.

Мөнгөн тэмдэгт: JPY

Салбар чиглэл	Хичээл	Төлбөр (4 сарас 9 сар)
Хүмүүнлэгийн ШУ	Ерөнхий хичээл (нийт 50 удаа)	55,000
	Математик 1 (нийт 40 удаа)	50,000
Хүмүүнлэгийн , Байгалийн ШУ	TOEFL/TOEIC (нийт 30 удаа)	35,000
Байгалийн ШУ	Физик (нийт 30 удаа)	50,000
	Хими (нийт 30 удаа)	50,000
	Математик 2 (нийт 30 удаа)	50,000

※Хичээлийн төлөвлөгөө болон төлбөрт өөрчлөлт орох магадлалтай. Сургуульдаа элсэн орсны дараагаар лавлана уу.

8. Бүртгэлийн хураамж болон сургалтын төлбөр төлөх дансны мэдээлэл

Бүртгэлийн хураамжийг бүрдүүлсэн баримт бичгийн хамт төлөөлөгчийн газарт төлөх эсвэл доорх данс руу шилжүүлнэ үү. Мөн оршин суух зөвшөөрөл гарсны дараа сургалтын төлбөрөө доорх данс руу шилжүүлнэ үү.
 ※Сургалтын төлбөр зэргийг бэлэн мөнгөөр хүлээн авах боломжгүйг анхаарна уу.

1. Олон улсын гуйвуулга хийх дансны мэдээлэл

Bank name	MUFJ Bank, Ltd. Jinbocho Branch
Bank address	No.2-2, Kandajinbocho, Chiyoda-ku, Tokyo, JAPAN
Bank's phone	+81-3-3263-1223
SWIFT	BOTKJPJT
A/C Number	2161685
A/C Name	OHARA Japanese Language School
Beneficiary's Address	No.4-14, 1-Chome, Funabori, Edogawa-ku, Tokyo, JAPAN
Beneficiary's phone	+81-3-3237-7120

2. Япон дахь дотоод гуйвуулга хийх дансны мэдээлэл

銀行名	三菱 UFJ 銀行	支店名	神保町支店
種類	普通	口座番号	2161685
口座名義	オオハラニホンゴガクイン		
銀行住所	東京都千代田区寛大神保町 2 - 2		

※Гуйвуулгын шимтгэлийг шилжүүлэгч хариуцна.

9. Элсэлтээс татгалзах (цуцлах) үед төлбөрийн буцаан олгох тухай журам

Нэгэнт төлсөн шалгалтын хураамж, элсэлтийн төлбөр, сургалтын төлбөрийг зарчмын хувьд буцаан олгохгүй. Гэхдээ дараах тохиолдлуудад манай сургуулийн тогтоосон журмын дагуу буцаан олгоно.

1. *Оршин суух зөвшөөрөлийн гэрчилгээ гараагүй тохиолдолд* → Бүртгэлийн хураамжаас бусад бүх төлбөрийг буцаан олгоно.
2. *Оршин суух зөвшөөрөлийн гэрчилгээ олгогдсон боловч виз мэдүүлэлгүй, Японд ирэхээ цуцлах тохиолдолд* → Бүртгэлийн хураамж болон элсэлтийн төлбөрөөс бусад бүх төлбөрийг буцаана. Төлбөрийн буцаалт хийхэд оршин суух зөвшөөрөлийн гэрчилгээний эх хувь болон элсэлтийн зөвшөөрлийн бичгийг сургуульд буцаан илгээх шаардлагатай.
3. *Оршин суух зөвшөөрөлийн гэрчилгээ гараад, виз мэдүүлсэн боловч гадаад дахь консулын газар (Японы элчин сайдын яам, консулын газар гэх мэт) виз олгоогүй тохиолдолд* → Бүртгэлийн хураамж болон элсэлтийн төлбөрөөс бусад бүх төлбөрийг буцаана. Төлбөрийн буцаалт хийхэд гадаад дахь консулын газраас виз олгоогүйг батлах бичгийг илгээх мөн элсэлтийн зөвшөөрлийн бичгийг буцаах шаардлагатай.
4. *Оршин суух зөвшөөрөлийн гэрчилгээ гарч, визээ авсан боловч Япон руу ирэхээс өмнө элсэлтээс татгалзсан тохиолдолд* → Визийг ашиглаагүй байх мөн виз нь хүчингүй болснийг шалгасны үндсэн дээр, бүртгэлийн хураамж болон элсэлтийн төлбөрөөс бусад бүх төлбөрийг буцаана. Энэ тохиолдолд ч элсэлтийн зөвшөөрлийн бичгийг буцаах шаардлагатай.
5. *Сургуульд элсэн суралцаж байх явцдаа дэвшин суралцах болон бусад зайлшгүй шалтгааны улмаас сургуулиас гарах тохиолдолд* → Сургалтын төлбөр буцаан олгох тусгай журамын дагуу тооцоо хийгдэнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийн захиргаанаас лавлана уу.

10. Бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт

[Суралцах хүсэлт гаргагч]

№	Бичиг баримт	Тайлбар
1	Сургуулийн анкет	• Паспортын овог нэрийг бичих • Боловсролын намтарын хүснэгтэнд сургуулийн нэр, элссэн болон төгссөн огноо бичнэ. Төгсөлтийн гэрчилгээ зэрэг албан ёсны бичиг баримтны мэдээлэлтэй зөрөөгүй эсэхийг хянаарай. • Анкетыг бүрэн бөглөнө үү. Сургалтын зардал батлан даагчийн мэргэжил, албан тушаал, ажлын газрын мэдээлэл гэх мэт мэдээлэл нь тодорхойлолтын агуулгатай нийцэж байгаа эсэхийг шалгаарай. (Ажлын болон боловсролын түүхэнд хоосон тасарсан цаг хугацаа үлдээлгүйгээр бичих. Сургуулийн элсэлтийн шалгалтанд бэлдэж байсан эсвэл цэргийн алба хашиж байсан бол зарцуулсан цаг хугацаагаа бичээрэй). • Анкетын 4-р хуудсанд гарын үсэг зурна. Хамгийн сүүлд суралцсан сургуулиа төгсөөд 5-аас дээш жил болсон бол: • Өргөдлийн 4 дэх хуудсанд, сурах шалтгаан болон манай сургуулийг төгссөний дараах замналын төлөвлөгөөг нарийвчлан бичнэ үү. Энэ мэдээллийг Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газарт хүргүүлнэ.
2	Цээж зураг	• Зургийг 3 сар дотор авахуулсан байх • Эгц урдаас, фон цагаан, нүүрний хэлбэр тодорхой байх.
3	Паспорт, иргэний үнэмлэх	Япон улсад зорчсон түүхтэй хүмүүс Япон руу орж гарсан бүх тэмдэглэл бүхий хуудсуудын хуулбарыг бэлтгэнэ үү.
4	Сүүлд төгссөн сургуулийн гэрчилгээ эсвэл сургууль төгссөн тухай тодорхойлолт	Хамгийн сүүлд төгссөн сургуулийн төгсөлтийн гэрчилгээ, батламжийн хуулбарыг илгээх. ※<i>Нөхцөл байдалаас шалтгаалан эх хувь шаардлагатай болох магадлалтай.</i> Одоо сургуульдаа суралцаж байгаа ба Японд ирэхээсээ өмнө сургуулиа төгсөх бол Сургуулиасаа “Суралцаж байгаа ба сургуулиа төгсөх нь үнэн бол гэсэн утга бүхий тодорхойлолт” авах шаардлагатай. ※<i>Хятадаас өргөдөл гаргагчид: CHSI болон CDGDC-аас гаргасан баримт (боловсролын байдалын баталгаа, Их сургуулийн шалгалтын мэдээллийн тухай баримт гэх мэт)</i> ※<i>Вьетнамаас өргөдөл гаргагчид: VN-NARIC-аас "Ахлах сургууль төгссөн гэрчилгээг баталгаажуулсан баримт" тус тус шаардлагатай.</i>
5	Сүүлд төгссөн сургуулийн дүн	Дүнгийн тодорхойлолт болон гэрчилгээ дипломны хавсралтын хуулбар ※ <i>Нөхцөл байдалаас шалтгаалан эх хувь шаардлагатай болох магадлалтай.</i>

6	Япон хэлний мэдлэг батлах бичиг	Япон хэлний түвшин тогтоох шалгалтанд тэнцсэн бол гэрчилгээгээ, шалгалтанд тэнцээгүй бол дүнгийн хуудсаа хавсаргах Шалгалтын хариугаа хүлээж байгаа бол шалгалтанд бүртгүүлсэн хуудсаа илгээх. Япон хэлний сургалтанд суугаад төгссөн бол Батламжинд дараах мэдээлэлийг тодорхой бичсэн эсвэл хавсаргасан байх 1. Сургалтын хугацаа (150 цаг ба түүнээс дээш) 2. Ирцийн хувь 3. Сургалтын агуулга 4. Курсын нэр 5. Курсын төгсөх зорилтот түвшин 6. Ашигласан сургалтын материалын нэр
7	Ажлын тодохойлолт (ажиллаж байгаа бол)	Ажиллаж буй хугацаа, үйл ажиллагааны чиглэл, албан тушаал зэрэг мэдээлэл бичигдсэн байх
8	Сүрьеэгүйг батлах гэрчилгээ (зөвхөн заасан орнуудад) 	Филиппин, Вьетнам, Хятад, Индонез, Непал, Мьянмар улсын иргэншилтэй өргөдөл гаргагчид заавал гаргана уу. Гэрчилгээг Японы засгийн газраас нэрлэсэн эмнэлгийн байгууллагаас гаргуулсан байх шаардлагатай. Дэлгэрэнгүй мэдээлэл болон эмнэлгийн жагсаалтыг доорх URL хаягаар орж үзнэ үү. https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/kenkou_iryuu/kenkou/kekaku-kansenshou03/index_00006.html
9	Япон хэл дээрхи орчуулга	1-8 дугаарын бүх материалыг Япон хэл рүү орчуулах

【Сургалтын төлбөр батлан даагч】

№	Баримт бичиг	Тайлбар
10	Санхүүгийн батлан даагчийн амлалт бичиг (Сургуулийн маягт)	• Яагаад, ямар зорилго, шалтгааны улмаас санхүүгийн батлан даагч болсон тухайгаа тодорхой бичих • Төлбөр, амжиргааны зардал илгээх арга хэрэгсэлийг нарийн тодорхой бичих. • Төлбөр болон амжиргааны зардалд зориулан илгээх мөнгөн дүнг тодорхой бичих. • Маягтын доор хэсэгт гарын үсэг зурах.
11	Санхүүгийн батлан даагчийн гэр бүлийн гишүүдийн жагсаалт (Сургуулийн маягт)	• Санхүүгийн батлан даагчийн гэр бүлийн гишүүн болон хамт амьдардаг хүмүүсийн мэдээлэлийг бичих. (Тусдаа болон хамт амьдардаг гэр бүлийн бүх гишүүнийг оруулах) • Батлан даагчийн гарын үсэг зурах.
12	Санхүүгийн батлан даагчийн гэр бүлийн бүрэлдэхүүнийг нотлох баримт бичиг	• [Гадаадаас] - Өрхийн ам бүлийн хорооны тодорхойлолт • [Японоос] - Өрхийн бүх гишүүдийн оршин суугчийн бүртгэл (世帯全員の住民票)
13	Хамааралыг нотлох баримт бичиг	• Төрсний гэрчилгээ, төрөл садангийн лавлагаа зэрэг ※Санхүүгийн батлан даагч болон суралцагчийн хоорондын хамааралын тухай
14	Дансны үлдэгдлийн тодорхойлолт (эх хувь)	• Дансны дугаар, валютын нэр бичигдсэн байх. • Хэвлэгдсэн хугацаа нь сүүлийн 3 сарын дотор байх. • Хангалттай үлдэгдэлтэй байх.
15	Мөнгөний эх үүсвэрийг нотлох баримт бичиг (сүүлийн 1 жилийн хугацаанд)	Дансны үлдэгдэлийн тодорхойлолт дох мөнгөн дүнг хэрхэн бүрдүүлсэнийг нотлох баримт. Үүнд: Орлого зарлагын дэлгэрэнгүй хуулга (эх хувь) эсвэл хадгаламжийн дэвтрийн хуулбар г.м. ※Агуулгаас хамааран 3 жилээр шаардлагатай үе бий.
16	Санхүүгийн батлан даагчийн ажил мэргэжлийг нотлох баримт бичиг	• Ажлын газрын тодорхойлолт ※Доорхи мэдээлэлийг оруулах ① Ажлын газрын нэр болон холбоо барих хаяг, утас, мэйл, вэб сайт г.м. ② Ажилласан хугацаа ③ Ажил мэргэжил ④ Албан тушаал ⑤ Ажил олгогч компанийн удирдлагын бүртгэлийн дугаар болон татварын дугаар (Вьетнамын иргэдэд хамаарна) • Бизнес эрхлэх зөвшөөрөл, бүртгэлийн гэрчилгээний хуулбар гэх мэт.

17	Санхүүгийн батлан даагчийн орлогыг нотлох баримт бичиг (сүүлийн 1 жилийн)	• Татварын (татвар ногдуулсан) тодорхойлолт эсвэл орлогын тодорхойлолт гэх мэт. ※Агуулгаас хамааран 3 жилээр шаардлагатай үе бий.
18	Япон хэл дээрх орчуулга	10-17 дугаарын бүх материалыг Япон хэл рүү орчуулах

Бичиг баримт боловсруулахад анхаарах зүйлс:

1. Гэрчилгээ зэрэг баримт бичгээс бусад тодорхойлолт, банкны хуулга зэрэг материалууд нь 3 сарын дотор хэвлэгдсэн мөн эх хувь байх.
※Гэрчилгээ зэрэг баримт бичиг: Төрсний гэрчилгээ, төгсөлтийн диплом гэх мэт нэг удаа олгодог баримт бичиг.
※Тодорхойлолт г.юм: Хүсэлт гаргасан тохиолдолд хэд хэдэн удаа авч болох баримт бичиг. (жишээ нь Сургуулийн, ажлын тодорхойлолт мөн дансны үлдэгдлийн тодорхойлолт, хуулга гэх мэт.)
2. Баримт бичиг дутуу байх тохиолдолд элсэлтийн материал хүлээн авах боломжгүй.
3. Диплом зэрэг эх хувиар хүлээж авсан материалыг буцаан олгоно. Бусад тодорхойлолт болон хуулбар материал нь буцаагдахгүй.
4. Паспорт шинээр авах хүмүүс нь доорхи зүйлсийг
※Сургуулийн анкетанд нэрээ бичихдээ гадаад паспортны бичилттэй ижил бичих. Зөв бичсэн эсэхээ сайтар нягтална уу.
※Сургуулийн анкетанд бичсэн нэр нь "виз" болон Японы "оршин суух карт" дээр бичигдэнэ.
※Сургуулийн анкет болон паспорт дээрх нэрийн бичилт нь ялгаатай бичигдсэн тохиолдолд виз олгогдохгүйг анхаарна уу.
5. Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газрын заавар журмын дагуу бүрдүүлэх бичиг баримтанд өөрчлөлт оруулах тохиолдол бий. Энэ талаар сургууль эсвэл орон нутгийн албан ёсны төлөөлөгчийн газраас лавлана уу.


11. Хувийн мэдээлэлийн нууцлалын тухай

Манай сургууль нь хувийн мэдээлэлийг доор дурьдсан холбогдох хууль тогтоомж болон Охара Эрдэмийн хүрээлэнгийн тогтоосон нууцлалын бодлогын дагуу ашиглах болно.

1. Хүлээн авсан бичиг баримт, материал дахь нэр, хаяг зэрэг хувийн мэдээлэлийг элсэлтийн материал бүрдүүлэх, сонгон шалгаруулах, элсэлтийн зөвшөөрөл олгох зэрэгт ашиглана. Мөн түүнчлэн Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газарт оюутны оршин суух зөвшөөрөл хүсэх өргөдөл гаргахад шаардлагатай бичиг баримтыг бэлтгэхэд ашиглана. Мөн суралцаж буй оюутануудынхаа хувийн мэдээлэлийг доорхи үйл ажиллагаанд ашиглана.
① Сургалттай холбоотой аливаа үйл ажиллагаанд (сургалтын зааварчилгаа г.м) ашиглана.
② Оюутан сурагчидаа үзүүлэх тусламж, дэмжлэг (эрүүл мэнд хамгаалах, хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух тухай хууль тогтоомжийн дагуу бичиг баримт бэлтгэх, тэтгэлэгийн өргөдөл гаргах гэх мэт)-т ашиглана.
2. Дээрхи үйл ажиллагааны хүрээнд сургуулийн туслан гүйцэтгэгчээр хамтран ажилладаг байгууллага нь шаардлагатай үед зохих журмын дагуу оюутны хувийн мэдээлэлийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн ашиглах тохиолдол бий.
3. Элсэгчдийн сонгон шалгаруулалтад ашигласан шалгалтын дүн болон бүрдүүлсэн баримт бичгүүд, түүнчлэн сургуульд элссэний дараа өгсөн шалгалтын дүн болон бусад мэдээллүүдийг дараа дараачийн элсэлтийн сонгон шалгаруулалтын тухай материал бэлдэх болон тайлан гаргах зэрэгт лавлах материал болгон ашиглах тохиолдол байна.

Дэлгэрэнгүй мэдээлэлийг манай сургуулийн захиргаанаас лавлах эсвэл Охара Эрдэмийн хүрээлэнгийн вэб сайтаас шалгах боломжтой.

<http://www.o-hara.ac.jp/about/privacy/index.html> (Япон хэлээр)



Хаяг	〒134-0091 Токио муж, Эдогава дүүрэг, Фунабори 1-4-14
Утас	+81-3-3237-7120
Факс	+81-3-5605-6133
Мэйл хаяг	info.ojls@mail.o-hara.ac.jp
Вэб хуудас	https://www.o-hara.ac.jp/abroad/japanese/